

**БОЛОВСРОЛЫН  
МЕНЕЖМЕНТ**

---

**2006 / 1**

Улаанбаатар хот  
2006 он

**CONTENTS**

**Education management theory and practice**

Teador Frik	Education structure and technology innovation	5
N.Naranchimeg	Strategical management of training organization	19
D.Narandelger and U.Sarangerel	Ways intellectual property evaluation and their models	38
Ch.Erdenechimeg	Understanding of educational quality	45
M.Amartuvshin	Pre-school organizational marketing	59
G6Gantsetseg	Khangai region's population education	72

**Training technology**

P.Uvsh	Adult training technology and its basic	79
S.Zulficar	Procedure developing training curriculum	86

**Human and Society**

R.Vandangombo	New perspectives on individual and social relations	98
Ya.Byambasuren	What is poverty?	115

**Culture**

D.Tungalag	Government view on cultural activity, United Kingdom cultural management structure and activity trends	120
M.Otgonchimeg	Suggestion on cultural sector privatization thought contract	131
Z.Davaasuren	Image	138

**Information**

G.Galnaran	Project "Open school for public"	145
	New publication	146



**Теодор Фрик**

Бид энэ дугаартаа АНУ-ын Индианагийн их сургуулийн Боловсролын сургуулийн профессор Теодор Фрикийн "Боловсрол, боловсролын тогтолцоо, технологийн шинэчлэл" өгүүлгийг профессор Пүрэвийн Увшийн орчуулснаар нийтэлж байна. Энэ өгүүлэлд боловсролын тогтолцоог технологиор дамжуулан өөрчлөхөд нөлөөлөх гол хүчин

зүйлсийн харилцааг тодорхойлж тэдгээр нөхцөл байдлын өнөөгийн болон хэтийн төлвийг харьцуулан гаргаж харуулсан юм. Боловсролд технологийн өөрчлөлт хийхгүйгээр бусад өөрчлөлтийг чанарын өндөр түвшинд хэрэгжүүлэх боломж хомс гэдэг санаа энэ өгүүлэлд нэвт шингэсэн. Энэ өгүүлэл манай багш, судлаачид, боловсролын удирдах ажилтнуудын сонирхлыг татна гэдэгт найдаж байна. Бид цаашид Индианагийн их сургуулийн эрдэмтдийн бүтээлээс цувралаар нийтэлж байх болно.

Сэтгүүлийн зөвлөл

**БОЛОВСРОЛ БА БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО, ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ.**

Боловсролын өөрчлөлтөд технологийн үүргийн тухай анх би боловсролын гүн ухаан заадаг профессор Элизабет Стэйнертэй хамт ажиллаж, хичээл заалгаж байхдаа сонссон. Тэрээр боловсролын мөн чанар бол багш, суралцагч, сургалтын агуулга, хэрэглэгдэхүүн зэргээс бүрдэх бөгөөд боловсролыг сургалтыг чиглүүлэх багш, сурч, мэдэхийг эрмэлзэх суралцагч, эзэмшвэл зохих агуулга, сурах, чиглүүлэх ажиллагааг хангах хэрэглэгдэхүүнгүйгээр төсөөлөх боломжгүй юм гэдэгсэн.

Боловсрол бол нийгэм, соёл иргэншлийн хүрээлэн байгаа орчинг ч бас хамарна. Боловсролын өөрчлөлтөд технологийн гүйцэтгэх үүргийн талаарх санал бодлоо боловсролын мөн чанарыг илэрхийлэх дээрх бүрэлдүүлбэрүүд дээр тайлбарлая.

**Боловсрол нь багшгүйгээр хэрэгжихгүй.**

Багш бол сургалтыг чиглүүлэгч буюу хөтөлгөчийн нэг мөн. Чиглүүлнэ гэдэг нь удирдаж зааварлахын нэр бишээ. Хичээл заана гэхлээр л бид зааварлаж удирдах, өөрөөр хэлбэл мэдээлэл танилцуулах, асуулт асуух, эргэх холбоо бий болгох, оюутныг шахаж шаардах тухай л боддог. Багш шахаж шаардахгүйгээр ч сургалтыг чиглүүлж болдог. Үүний тодорхой жишээ бол сургалтын Монтэссори тогтолцоо мөн. Монтэссори сургалт нь ямар ч захирамжлалгүйгээр суралцагчд ердийн нөхцөлд хөтөлбөрийн олон хувилбараар дадал хэвшлийн замаар суралцдаг. Монтэссори сургалтын үед багш уламжлалт сургалтынх шиг биечлэн зааварлаж чилүүлдэггүй.

Би college-д багшилж байхдаа ангид хичээл заахаас илүү, дийлэнх цагаа ангиас гадуурх сургалтын ажилд зарцуулдаг байсан. Оюутнууд асуух, зөвлөх шаардлагатай бол сургуулиар ирж надтай уулзахаас гадна надад э-майл бичнэ. Түүнийг нь би уншаад, гэртээ урих буюу гэр рүү утсаар ярихыг зөвлөдөг байлаа. Би мэдээлэл авч болох эх сурвалжууд, ном, сурах бичиг, гарын авлага, цахим тоолуурын машины программ болон энэ талаар асууж болох боломжтой оюутны нэрийг хүртэл хэлдэг байлаа. Түүнчлэн өөрийн болон бусад хүмүүсийн бичсэн ном, бүтээл, өөрт байгаа цахим тоолуурын машины файлыг түр хэрэглүүлдэг байсан. Оюутнууддаа "үүнийг уншаад, үүнийг бие дааж хийгээд ир, тэгээд хамтдаа тогтож ярилцъя" гэж байнга хэлдэгсэн.

Би одөрт ангид ганц, хоёр цагийн хичээл заагаад, ихэнх цагаа надаас зөвлөгөө, туслалцаа авахаар ирж байгаа оюутнуудтай уулзаж, ярилцаж, хамтран ажиллахад зардаг байсан юм. Ингэж оюутантай нүүр тулж ажиллах байр маань анги танхим, миний ажлын өрөө, үүд, хонгил дах буйдан гээд хаана л бол хаана байж болдог. Оюутантай ажиллахад харилцаа холбооны мэдээллийн хэрэгслэл-утас, э-майл болон хувилж олшруулсан материалыг өргөн ашиглавал үр дүнгээ өгдөг. Товчхондоо миний багшийн ажил зааварчлага, удирдамжийг шууд тулгаж өгөхөөс зайлсхийх явдал байлаа.

**Боловсрол сурахыг эрмэлзэгч оюутангүйгээр байх боломжгүй**

Стэйнэрийн хэлсэнчлэн, хэрэв суралцагч сурч, мэдэхийг үл хичээх аваас боловсрол ахихгүйн дээр хэрэгжих боломжгүй болно. Суралцагч ангид хүрэлцэн ирэх нь сургалт явагдаж, боловсрол эзэмшиж байна гэсэн үг биш юм. Энд багшийн оновчтой дэмжлэгээр тэтгэгдсэн сурах идэвх, эрмэлзэл нэн чухал байдаг. Харин энэ дэмжлэг нь нүүр тулсан хэлбэрээр биш, ангид нийтэд нь хандсан байх нь илүү үр дүнтэй болдог.

**Боловсрол агуулгагүйгээр хэрэгждэггүй.**

Агуулга гэдэг нь үеэс үед дамжиж байгаа, харилцан өвлөж байгаа тэр зүйл юм. Оюутнууд өөрийн ойлголт, бодол эрмэлзэл, хувийн үнэт зүйл, итгэл үнэмшлийг төлөвшүүлэхийн тулд сургалтын агуулгатай танилцах учиртай.

Агуулга гэдэг нь зөвхөн математик, англи хэл, биологи гэдэг ухагдахуунаар хязгаарлагддаггүй. Агуулга нь ном, компьютерийн программ, зурагтын дэлгэцнээс олдохгүй. Агуулга бол хүний үзэл бодол, санаа, хүсэл тэмүүлэл, мэдрэмж, хандлага, биеэ авч явах зэрэг ойлголт юм. Мэдээллийн хэрэгслэл, ном, зурагтаас олж авч байгаа мэдлэг, мэдээлэл бол агуулгын төлөөлөл төдий зүйл юм. Агуулга бол хэлээр дамжин билэгдлийн байдлаар илэрнэ. Жишээлэхэд жүжиг санааг илэрхийлэх авч агуулгыг тэр бүр төгс илэрхийлэхгүй байж болно.

**Боловсрол бол хэрэгжих тодорхой суурь нөхцөл, орчингүйгээр хэрэгждэггүй.**

Энэ бол сургуулиас өргөн ойлголт юм. Жишээлбэл гэр бүлийн нөхцөл байна. Гэр бүлийн нөхцөлд хүн дан ганц сайныг сурахаас гадна саар зүйлд ч суралцаж болдог. Боловсролын орчин, нөхцөлийг судалж үзэхэд, энэ нь дандаа эерэг ч байдаггүй байна. Боловсролын бас нэг нөхцөл бол хот, суурингийн амьдрал гэж хэлж болно. Тухайлбал охид, хөвгүүдийн клуб, итгэгчдийн байгууллага зэрэг нь ядуу, салсан гэр бүлийн гишүүд, гэр бүлгүй залуучуудад суралцах нөхцлийг бүрдүүлж, мэдээлэл, мэдлэг эзэмших аргад сургадаг. Эдгээр байгууллагуудад ажиллаж байгаа хүмүүс өөрсдийгөө хүмүүжүүлэгч гэж үздэггүй ч үнэн хэрэгтээ жинхэнэ сургагч, хүмүүжүүлэгч байдаг. Залуучууд ч гэсэн ийм байгууллагад сайн дураараа очдог. Зарим нь энэ үйл ажиллагаанд татагдан оролцсоноор хорт зуршлаасаа татгалзах, бүрмөсөн хаях тохиолдол цөөнгүй байдаг. Залуучуудын ийм байгууллагууд бол боловсрол эзэмшиж байгаа "өөр" нэг хэлбэр бөгөөд өнөөгийн боловсролын албан бүтцэд ороогүй нэгэн өвөрмөц тогтолцоо юм.

**Боловсрол нь нийгмийн болон түүний соёлоор тэтгэгдсэн орчингүйгээр оршин байх үндэсгүй.**

Хотын дотор байгаа залуучуудын байгууллага боловсролын орчны хувьд үнэ, цэнэтэй газар байх учиртай. Гадаа орчин аюулгүй, эцэг, эхчүүд хүүхдээ сургуулиас тайван буцаж ирнэ гэдэгт итгэлтэй байх, элдэв хорт зуршлаас хөндий байна, сэтгэл зовнихгүй байна гэдэг нь боловсролын орчний гол үзүүлэлт болой. Эдгээр наад захын хэм, хэмжээ зөрчигдөхөд боловсролын таагүй

орчин үүсч сөрөг нөлөө бий болно. Зарим гэр бүлийн хүүхдээ үл хайхрах байдал, амьдралын таагүй орчин, түүнчлэн хотын доторх ариун цэвэр, хөдөөний нөхцөл байдал боловсролоор дамжин хүүхдийн ирээдүйд нөлөөлнө.

Боловсролын тогтолцооны талаар ярихад дээрх бүх нөхцөл бүрдэж байж сургалтын агуулга, хэрэгжилтийнх нь талаар өгүүлэх хэрэг гарна. Ийм болохоор одоо боловсролын тогтолцооны тухай асуудалдаа эргэж орьё.

### БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНЫ МӨН ЧАНАР.

Тогтолцоо гэдэг нь энгийнээр бодоход хэдэн хэсгээс бүрдэх бөгөөд тэд нэгдэн нэг цогц болж байж хэрэгжих өвөрмөц нэгдэл юм. Гэхдээ эдгээр хэсгүүд хэдийд нийлж, хэсэг бүр нэгдэл дотроо биелэлээ олох нь сонирхолтой бөгөөд зөрчилтэй ойлголт. Ер нь бол төрийн, эрүүл мэндийн, цэргийн бизнесийн, боловсролын гээд олон тогтолцоо байдаг. Үүнээс үзэхэд тогтолцооны баримтлал нь боловсролын технологийн тухай бодлоос эх үндэстэй болох нь харагдана.

Боловсролын тогтолцооны тухай ярих болоход боловсролыг сургууль гэдэг ойлголтоос арай өргөн утгаар авч үзэх хэрэгтэй болно. Бидний хэрэглэж заншсанаар бол боловсролын тогтолцоонд багш, захиргаа, болон тухайн байрлалд байх боломжтой суралцагчдын тоог хамруулан авч үздэг. Гэхдээ энэ бол боловсролын тогтолцоог ангилал, зохион байгуулах нэг л арга зам гэдгийг хэлэх хэрэгтэй.

Боловсролын тогтолцоог илэрхийлэх өөр нэг зам бол боловсролын тогтолцоог бүрдүүлэгч гол дөрвөн хэсгийн хоорондын харилцаагаар илэрхийлэх явдал юм. Тогтолцооны хандлагын үүднээс дээрх дөрвөн бүрэлдүүлбэрийн хооронд зургаан янзын харилцан хамаарал байгааг би олж тогтоосон юм.

1. Багш, суралцагчийн хоорондын харилцаа
2. Суралцагч, агуулга хоорондын харилцаа
3. Багш, агуулгын хоорондын харилцаа.
4. Суралцагч, нөхцөл байдлын хоорондын харилцаа.
5. Багш, нөхцөл байдлын хоорондын харилцаа.
6. Агуулга, нөхцөл байдлын хоорондын харилцаа.

Долоо дахь хамгийн чухал харилцаа бол боловсролын тогтолцоо болон түүний хүрээлэн байгаа орчны хоорондын харилцаа байгаа юм.

Сургуулийг технологиор дамжуулан өөрчлөх тухай ярихдаа бид дээр дурьдсан долоон харилцааны харилцан хамаарлыг зөв тогтоох явдал байна.

Одоо бид манай тогтолцооны загварт дээрх долоон харилцаагаар дамжуулан боловсролын тогтолцоог хэрхэн өөрчлөх талаар авч үзнэ.

### ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТӨӨР ДАМЖУУЛАН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ НЬ.

Тогтолцооны загвар бол өнөөгийн боловсролын тогтолцооны бүтцүүдийн хоорондын, дээр бидний авч үзсэн долоон харилцан хамаарлын хэв шинжийг үлгэрлэн харуулахад туслах юм. Ингэхдээ би одоогийн сургуулиудад барьж байгаа тогтолцооны байдлыг цаашид хэрхэн өөрчилж болох хувилбарыг тулгах биш санал солилцох зорилгоор харьцуулан гаргахыг зорилоо.

#### 1. Багш- суралцагчийн харилцаа.

ОДОО.

Багш суралцагчдад мэдээллийг амаар болон харуулж тайлбарладаг. Багш суралцагчдад унших зүйл болон дасгалыг бүхлээр нь дамжуулна.

Багш суралцагчдад гэрийн даалгавар болон сорилууд өгөх замаар тэдний ахицын эргэх холбоог хангана.

Багш суралцагчийн анги дахь үйл ажиллагааг идэвхжүүлэх биш зөвхөн хийх ажлыг нь чиглүүлдэг.

Багш шавийнхаа асуултанд хариулдаг.

Багш нар зааж зааварлах ажлаа хэт нарийвчладаг нь тухайн нөхцөлийг тэр бүр харгалздаггүй.

Багш ангид үймүүлсэн хүүхдийг сахилгажуулах арга хэмжээ авдаг.

Сурагчид судлах зүйлээ ойлгоогүй үедээ башаасаа асууж лавладаг.

Сурагчид багшийн зааж байгааг сонсож бас хараагаар хүртдэг.

Багш заах материалаа сонгож сурагчид хэр удаан судлахыг шийддэг.

Багш, сурагчийн хоорондын харилцаа бичгээр дамжих бус халз нүүрээ харсан байдалд хэрэгжинэ.

Багш сурагчдын хоорондын сурах, сургах харилцаа гол төлөв тодорхой хугацаанд \улирал, хичээлийн жил гэх мэт\ хэрэгжинэ.

## ЦААШИД.

Боловсролын тогтолцоог өөрчлөн байгуулахын тулд багш, суралцагч хоёрын хоорондын харилцааг хэрхэн өөрчлөх вэ? Хэрэв суралцагчдад зориулсан мэдээллийн түгээлтэнд цахим технологи компьютерт суурилсан зөвлөгөө, ажиллавар, дасгал, видео хэрэглэвэл сургалтанд зарим өөрчлөлт гаргаж болмоор санагддаг.

Нэгд, сурагч тухайн хугацаанд зөвхөн ганц биш хэд хэдэн багштай ажиллаж болдог. Багш бүр компьютерт суурилсан технологиор дамжуулан олон оюутантай харилцах боломжтой болно. Энэ харилцаа багш, сурагчийн хэн хэнийх нь хувьд албан бус. Нүүр нүүрээ харж хэл байдалтай биш байна.

Түүнээс гадна анги буюу бүлэгтэй ажилладаг багш сурагч бүртэй харилцах арга олж өөрчлөх хэрэг гардаг. Анги, бүлгийг мэдээлээр хангах үүрэг хүлээсэн багшийн үйл ажиллагааны төлөвлөлтөд өөрчлөлт орж, сурагч бүртэй ажиллах шинэ арга барил эзэмших эхлэл тавигдана. Өмнө нь зааварлагч байсан багш маань одоо сурагчийн асуултад хариулагч, сургалтын агуулга, эргэх холбооны талаар туршлага солилцох чадвар бүхий менежер болж хувирдаг. Шинэ арга барилаар ажиллах багш сурагч бүрийн онцлог, тэдний эрэлт хэрэгцээ, сонирхлыг мэдэх учиртай.

## 2. Суралцагч-агуулга хоорондын харилцаа.

## ОДОО

Сурагчид хичээлийн гол агуулгыг утга учир багатай, амьдралаас тасархай гэж үздэг.

Суралцагч, агуулга хоёрын хоорондын харилцаа нь сонсох, үзэх, унших зэрэг идэвхгүй хэлбэрээр хэрэгждэг.

Сурагчид хичээлийн агуулгатай хэтэрхий хийсвэр байдлаар харилцдаг. Энд бодитой, үнэн харилцаа үгүйлэгддэг.

Сурагчид агуулгыг хэвшсэн, тогтонги маягаар хүлээж авдаг.

Суралцагчид судлах агуулгаа өөрөө сонгох нь маш ховор байдаг.

Сургалтын хугацаа шахуу, давчуу байдгаас сурагчид агуулгаа бүрэн эзэмшиж чаддаггүй.

Суралцагчдын судлах хичээлийн агуулга нь уйтгартай, тэднээс хол хөндий байдаг.

## ЦААШИД.

Энэ харилцааг боловсролын тогтолцоонд дүйцүүлэн хэрхэн өөрчлөх вэ? Энэ харилцааг ном унших хэлбэрээс технологиор дамжин хэрэгжих харилцаа болгож өөрчилснөөр сурагчдын сургалтын үйл ажиллагаанд оролцох идэвх дээшилдэг. Технологийн хувьд сайтар бэлтгэгдсэн материал нь асуултанд шууд хариулах, алдааг шууд засах, эргэх холбоог хангах бололцоо олгодог. Компютерийн программаар хангагдсан сургалтын үед сурагч зөв, буруу, алдаа оноог даруй магадлаж эргэх холбоог дор нь тогтоодог.

Ийм харилцааг бий болгосноор суралцагч сургалтын үйл явцын хурдыг хянах, хэрэгцээт цагаа зөв зарцуулах болдог. Тодорхой нэг агуулгаас нөгөөд шилжих үйл явц бүлгийн амжилтаар биш, тухайн суралцагчийн хувийн ахицаар тодорхойлогдох сайн талтай. Суралцагч сургалтын агуулгыг эзэмшиж, идэвх өссөнөөр өөртөө итгэх итгэл дээшилж, үрам зориг орно. Эцэст нь сургалтын агуулга технологжсоноор, сурагч гардан хэрэглэх материалууд бий болсноор хичээлийг амаар болон бодот байдлаар явуулах уян хатан, хурдацтай явуулах боломж нээгдэнэ.

## 3. Багш- сургалтын агуулгын харилцаа.

## ОДОО.

Сургалтын агуулга нь тухайн багшийн их, дээд сургуульд олж авсан мэдлэгээр тодорхойлогдоно.

Энэ нь дээр дурдсан суралцагч, агуулгын хоорондын харилцаатай адилхан хязгаарлагдмал юм.

Хичээлийн ямар агуулгыг хэдийд судлахыг багш тэр бүр хянаж чаддаггүй. Хяналтыг ном сурах бичиг болон улсын болон бүс нутгийн зааварчлагаар хэрэгжинэ.

Багш гол төлөв бусдын зохиосон ном сурах бичиг бичвэр, хальс, компютерын программ хэрэглэх болдог.

## ЦААШИД.

Багш сурагчийн нэгэн адил ийм технологжсон материал хэрэглэснээр сургалтын үйл ажиллагаа илүү дөхөм болно. Багш нар компютерийн технологийг ашигласнаар сургалтын удирдамж, зааварчилгааг өрөө бий болгох боломжтой болно. Тэр ч байтугай сургалтын агуулгыг тухайн хичээлд дүйцүүлэн зохицуулах, заримыг нь шинээр хийх боломжтой болно.

#### 4. Сурагч – нөхцөл байдлын харилцаа.

ОДОО.

Суралцагчид том байшинд, ханхай өрөөнүүдэд хичээллэдэг.

Ижил насны, нэг ангийнхантайгаа сургууль дээр бүх цагаа өнгөрөөдөг

Хичээлийн хуваарь, хонх, сургуулийн албан ёсны төлөвлөгөө зэрэг нь суралцагчийн сурах бүх үйл ажиллагааг зохицуулж байдаг. Харин зуны цагт, үдээс хойш зэрэг зарим цаг хугацаанд ийм төлөвлөлт үгүйлэгддэг.

Сурагчид хэвлэмэл материал уншиж, уншсанаа эргүүлж бичихэд ихэнх цагаа зарцуулдаг.

Сурагчид багш руу нүүрийг нь харуулсан ширээний ард сууж хичээллэдэг.

Дунд сургуулийн сурагчдын хувьд гэхэд эзэмшсэн ном, хувцасны савнаас өөр чөлөөтэй гар хүрэх юм сургууль дээр байдаггүй.

Сурагч сургууль дээр байхдаа ертөнцөөс тусгаарлагдмал, олон нийттэй харилцах, интэрнэт ашиглах, утсаар ярих боломжгүй байдаг.

ЦААШИД.

Мэдээллийн технологи нь сурагчийг олон багштай харилцах бололцоог нээдэг болохоор сургуулийн өнөөгийн нүсэр бүтэц үеэ өнгөрөөх боломжтой. Ялангуяа дунд сургуулийн түвшинд тодорхой чиглэлээр дагнаж сургалт эрхлэх сургалтын нэгдсэн байгууллага, хөтөлбөрийг дэмжих хэрэгтэй гэсэн санал юм. Харин ийм бус тохиолдолд төвлөрсөн биш жижиг, жижиг сургуулиуд ч байж болох юм. Тодорхой хичээлээр мэргэшсэн багш нь цахим аялал хийж компьютерээр дамжуулан хичээлээ заах боломжтой болно.

Орчин үеийн боловсролын технологи нь түүхэнд анх удаа хичээлийн аргачлалыг хүн нэг бүрт хүргэх нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Багш бүлгээр хичээл заах хэрэгцээ байхгүй болж байгаа болохоор анги, бүлгийн тухай ойлголт үгүй болж, тухайн хичээлийг аль ч ангийн сурагч үзэж болдог. Бас сурагч хүч, бололцоондоо тааруулан сурах хэрэгцээгээ сонгох, янз бүрийн насны хүмүүс хамт суралцах, бас өөр, өөр хурдаар сурах боломж бий болно. Сургалтын зорилго бол анги дэвших биш, тухайн шатны материалын агуулгыг эзэмших явдал байна.

Сурагчдыг бүртгэх, хичээлийн үр дүнг хянах зарим ажлыг компьютер гүйцэтгэнэ. Тайлан, цаас зэрэг нь бүх тооцоог нарийн

тусгасан компьютерийн дискээр солигдоно. Энэ мэдээллийг багш, эцэг, эх, оюутны хэн нь ч, хаанаас ч үзэж болно.

Сурагч тухайн нутгийн бүх сүлжээнд холбогдсон, улмаар дэлхий нийтийн сүлжээнд холбогдсон ширээний ард сууж ажиллах болно. Ийм компьютер нь шууд харилцах интерактив видео, WORD ажиллагаа, мэдээллийн хайлт хийх зэрэг үйл ажиллагаатай байхын хамт бусад тоног төхөөрөмж байж болдог.

Одоогоор сургуулиудад сурагчдад зориулсан ном, сурах бичиг дэвтэр, хичээлийн хэрэгслэлээ хадгалах аюулгүй орчин байхгүй байна. Сурагчид ном хэрэгслэлээ хадгалах аюулгүй орчин байхгүй бол тэд чөлөөтэй байж суралцахгүй нь ойлгомжтой. Ихэнх гэр бүлд эцэг, эх, хүүхдүүд өөрийн гэсэн орон зайтай байдаг. Сургууль дээр хүүхэд дуртай цагтаа нэвтэрч байх компьютерийн сүлжээтэй байх боломж бий. Түүгээр ч барахгүй сурагчид гэртээ авч явдаг бага оврын компьютерын системтэй байж болно. Сурагчид өч төчнөөн жил ном сурах бичгийг гэр рүүгээ зөөсөнтэй адил компьютерийг яагаад авч явж болхгүй гэж. Бас гэртээ байгаа компютерын системийг сургуулийнхтай холбосон ч болохгүй нь юун. Зарим тодорхой программтай компьютерыг оюутнууд дундаа ч эзэмшиж болно. Эдгээр системд сурагч бүр тодорхой орон зай \Файл\ эзэмшиж тэнд өөрийнхөө тухай бүх мэдээллийг хадгалж болно.

Эцэст нь тэмдэглэхэд олон жил сурсан оюутанууд боловсрол эзэмшихийн тулд сургууль дээр байх шаардлагагүй байж болох юм. Тэрээр компьютерын сүлжээнд нэвтрэх боломжтой бол гэрээр ч суралцаж болно. Их Британийн нээлттэй Их сургуулийг үндэслэгчдийн нэг, дэд захирал асан Лорд Валтэр Пэрри "Хорин нэгдүгээр зуунд бид иймэрхүү гэрийн сургалтанд заавал шилжинэ. Учир нь бидний энэ сургалт дэндүү үнэтэй юм" гэж урьдчилан хэлсэн байдаг.

#### 5. Багш- нөхцөл байдлын харилцаа.

ОДОО.

Багш нар ангид, голцуу оногдсон цагт 20-30 оюутантай ажилладаг. Багш нар ямар ч том ангид ажиллалаа ч гэсэн орчноосоо тусгаарлагдсан, түгжигдмэл байдаг.

Багш нар ажлынхаа талаар бусад багш нартай санал солилцох боломж хомс байдаг.

Багш нар мэдээллээ самбар, прожектор ашиглан тайлбарладаг.

Багш нар сурагчдын бичгийн ажлыг уншиж улаан бэхээр тэмдэглэлээ хийж дүн тавьдаг.

Багш нар ихэнх цагаа сургуулиас гадуур гэртээ хичээлд бэлтгэх, сурагчдын бичгийн ажил, сорилыг засахад зарцуулдаг.

Багш нар гэртээ буюу олон нийтийн байгууллагад сурагчидтайгаа тун цөөхөн уулзаж ажилладаг.

Багшид ангид байгаа ширээнээс өөр хичээлийн материал, ном, гарын авлагаа хадгалах, хамгаалах орон зай байдаггүй. Мөн чанартаа энэ бол багшийн "ажлын байр" болой.

ЦААШИД.

Хийх нэг чухал өөрчлөлт бол багш нар хамгийн сүүлийн үеийн технологи чадварлаг эзэмшиж, харилцаж сурах явдал мөн. Тэд э-мэйл ашиглан сурагч, эцэг, эхтэй чанартай харилцах хэрэгтэй. Багш нар гэрээсээ компьютер болон утас ашиглан сурагчийг гэртээ байхад нь зааж, зөвлөж байх хэрэгтэй. Аудио-дүрслэлийн технологи ч багш, сурагчийн хоорондын харилцаанд ашиглагдсаар байх болно. Яриаг сурагчид утсаар сонсохоос гадна дүрс, бичвэрийг компьютерын дэлгэцнээ харж болно. Бас хамгийн чухал нь багш бүр өөрийн гэсэн компьютерын сүлжээ бас ярьж, дуут мэдээлэл явуулах, үлдээх утастай байгаа явдал юм.

#### 6. Агуулга- нөхцөл байдлын харилцаа.

ОДОО.

Их хэмжээний агуулга бичвэр, ажлын ном, толь бичиг, нэвтэрхий толь, сэтгүүлүүдийн хэлбэрээр хадгалагддаг.

Мэдлэг өөрчлөгдсөний дараа ч их хэмжээний агуулга тогтвортой байдаг бөгөөд өөрчлөгдөхийн тулд маш удаан хугацааг шаарддаг.

Түүнчлэн их хэмжээний агуулга тэмдэглэл, төлөөлөлийн бодитой хэлбэр гэхээс илүүтэйгээр үгэн буюу төсөөлөлийн хэлбэрээр оршдог.

ЦААШИД.

Компьютер мэдээллийг ашиглан асар их агуулгыг үзүүлэх боломжтой юм. Динамик үйлдэлүүдийг ч зураглан үзүүлж болно. Бичвэр, хөдөлгөөнгүй зураг, дүрс бичлэг, дуу авиа, график эсвэл хөдөлгөөнт зурагны хэлбэрээр оршиж байгаа агуулгыг дижитал хэлбэрээр эсвэл ижил тостэй байдлаар нь кодлож электрон, соронзон эсвэл харааны технологиор хадгалж болдог.

Энэхүү кодлогдсон мэдээлэл нь хэдхэн хормын дотор дэлхий даяар түгээгдэх боломжтой юм. Маршал МкЛуанын төсөөлж байсан дэлхийг хамарсан электрон тосгон аль хэдийн бодит байдал болжээ. Жишээ нь CNN-н Дэлхийн Мэдээгээр Персийн Булангийн дайныг дэлхий дахин шууд үзэх боломжтой болсоныг хэн хүнгүй мэдэж байгаа

#### 7. Боловсролын тогтолцоо- хүрээлэн байгаа орчны харилцаа.

ОДОО.

Эцэг эх болон нийгмийн бусад гишүүд сургуульд болж буй сурах болон заах үйл явцад тэр болгон оролцоод, холбогдоод байдаггүй.

Багш болон оюутнууд суралцах үйл явцад оролцохын тулд ургуульд явах хэрэгтэй болдог.

Оюутнууд сургуульд хязгаарлагдмал хугацаа зарцуулдаг (оройн цаг, амралтын өдрүүд, зуны амралт гэх мэт); ихэнх нь зав зай багатай байдаг; бүгд нэг л ижил цагт ирж ижил цагт буцдаг.

Ихэнх албан ёсны ажиллагаа, хөтөлбөрүүд нийгэмд биш сургууль дээр болдог.

Олон нийтийн сургуулиуд 5-аас 18 насныханд үйлчилдэг боловч нийгмийн бусад гишүүд албан ёсны боловсролоос гадуур хоцордог.

Багш нар улсын байгууллагуудаар дамжин батламжлал авдаг.

Орон нутгийнхнаар сонгогдсон сургуулийн зөвлөл захиргаа болон боловсролын тогтолцоог хянадаг.

Сургалтын материалүүд нь ихэвчлэн худалдааны зорилготой хэвлэгчдийн бүтээгдхүүнүүдээс сонгогдон батлагддаг.

Боловсролын тогтолцооны гадаад ерөнцтэй харилцах холбоо харилцаа ерөнхийдөө бага байдаг бөгөөд зурагт, хиймэл дагуулын болон цахим тооцооны машины холбоо төдийхнөөр хязгаарлагддаг.

Боловсролын тогтолцоо нь дээд зэргээр төвлөрсөн байдаг нь нийгмийн гишүүдийн боловсролын тогтолцоонд шууд оролцох, хянах боломжийг багасгадаг байна.

ЦААШИД.

Ирээдүйд теле харилцааны технологи нь боловсролын тогтолцоо болон хүрээлэн байгаа орчны хоорондын харилцааг асар ихээр өөрчлөх боломжтой болох юм. Нийлэгжүүлэлтийн үр дүнд Америкийн боловсролын тогтолцоо нь асар өргөн бөгөөд

өндөр хэмжээнд төвлөрсөн болж чаджээ. Түүнчлэн оюутнууд сургуульдаа нягт цагийн хуваарь баримтлах хэрэгтэй болсон юм. Теле харилцааны технологий үүнийг өөрчилж боловсролын тогтолцоог илүү нээлттэй, уян хатан болгож чадах юм. Сургуулийн дүүргүүд арай бага төвлөрч, жижиг сургуулиудад хуваагдаж болохоос гадна албан ёсны сургалтын зарим чухал ойлголтууд гэрийн буюу бусад сургуулийн бус хэлбэр шилжиж болох билээ. Түүнчлэн теле харилцааний технологи багш нар болон албан хаагчидыг ангид шууд "хүрч ирэх" боломжоор хангахаараа хүний нөөцийн хувид өндөр ач холбогдолтой болох юм. Энэхүү шинэ тогтолцоонд, "Багш"-н тухай ойлголтууд өөрчлөгдөж нийгмийн бусад гишүүд оройн цаг болон амралтын өдрүүдээр боловсрол хүлээж авах боломжтой болно.

Боловсролын тогтолцоог дахин зохион байгуулах олон зам байж болно. Энэ хүртэл би ерөнхий тогтолцооны онол(тогтолцоо, бүрэлдэхүүн, бүрэлдэхүүнүүдийн харилцаа, тогтолцооны орчин) болон боловсролын онол(багш, оюутан, агуулга, нөхцөл байдал)оос үндсэн ойлголтуудыг нь хэрэглэх гэсэн нэг бололцоог үзүүлэхийг зорьж байгаа билээ. Удаан хугацааны ажлын үр дунд ерөнхий тогтолцооны болоод боловсролын онолуудын үндсэн ойлголтуудын 7 харилцааг гаргаж, технологи тэдгээрийг хэрхэн өөрчилж болохийг, улмаар тэр нь хэрхэн боловсролын тогтолцоог дахин зохион байгуулах боломж өгөхийг жишээгээр үзүүлэн жагсаан бичсэн.

Юм хаашаа эргэхийг хэн мэдэх билээ! Гэхдээ би багш (ганц сургуулийн багш нар биш бүх багш нар) нар өөрчлөлт шинэчлэлтийг удирдан манлайлах ёстой гэж боддог.

### **БОЛОВСРОЛЫН ТЕХНОЛОГИ НЬ БАГШ ОЮУТНУУДЫГ ИЛҮҮ БОЛОМЖООР ХАНГАЖ НЭГ ҮГЭЭР ХЭЛБЭЛ ХҮЧИРХЭГЖҮҮЛЖ ЧАДНА.**

Технологийн тухай өгүүлсэн бяцхан хэсэгт, би багш сурагчдын юу хийж чадах, чадахгүйг технологи хэрхэн өөрчилсөн тухай би өгүүлсэн. Эртний багш нар сурагчдаа дагуулан агуй руу зураг үзэхээр явдаг байсан бол түүний дараахан нь сийлбэрүүдээр чухал мэдээлэл дамждаг болсон. Бичиг цаас удалгүй үүссэнээр, Философхич Плато өөрийн багш Сократын болон өөрийнхөө оюуны бүтээлийг 2400 жил хадгалан хүн төрөлхтөнд дамжуулах боломжоор хангагдсан билээ.

Би түүнтэй агаар нэгэн зүйлийг хийхийг энд оролдож байгаа юм. Харин бал цаасны оронд цахим тоолуур өмнө минь байна. Заримдаа би ажил гэр хоёрынхоо хооронд ном зөөдөг ч ихэвчлэн

бяцхан соронзон диск энэ ажлыг минь хөнгөвчилдөг. Сүүлийн үед соронзон диск зөөх шаардлага ч нэг их гарахгүй байгаагийн учир нь бид мэдээллийг гэрээсээ болон албан өрөөнөөсөө шууд хүрч болохоор электроноор хувиргаж болж болдогт байгаа юм.

Оюутнууд маань ч үүний үр шимийг амсаж байгаагийн нэг хэлбэр нь тэд ахмад оюутнуудын бичсэн бичлэгүүд ажлуудыг шууд цахим тоолуураар дамжуулан үзэж болдог болсон явдал билээ. Цаасан хэлбэрээр гарын авлага өгөхийн оронд багш нар оюутнуудад тухайн баримтны оршиж байгаа цахим хаягийг л өгөхөд хангалттай бөгөөд оюутнууд түүнийг уншиж, хувилж, хэвлэн ашиглах өргөн боломжтой үлдэж байгаа юм. Оюутнууд болон багш нар одоо том сийлбэрт чулуу эсвэл том том номнууд чирч явах шаардлагагүй болсон. Түүний оронд хувийн бичлэгийн төхөөрөмжүүд болон цахим тоолууруудаа авч явж электрон ертөнцөд нэвтэрэхэд л хангалттай. Багш болон оюутнууд цахим тоолуураар дамжуулан шууд харилцан ярилцах боломж хүртэл бий болсон байна. Цахим машинууд одоо үед 2 урсгалтай зам л болсон гэсэн үг. Цахим машин болон дүрс бичлэгүүд бидний эрин уеийн сийлбэрт чулуу, үзэг цаас, самбар шохой, ном дэвтэр болжээ.

Электрон технологи мэдээлэл цацах арга замыг үндсээр нь өөрчилж байна. Шинэ багш нар эдгээрийг яаж үр ашигтайгаар ашиглах талаар идэвхитэй суралцаж улам хүчирхэгжиж байна. Гэхдээ багш нарын зарим хэсэг нь машин тэдний үүргийг багасгана гэж боддогийн улмаас технологийг тийм ч таатайгаар хүлээн авч чадахгүй байгаа нь үнэн. Гэхдээ үүнд санаа зовох хэрэг байхгүй. Цахим тоолуурууд бол цахим тоолуурууд, тэд мэдээллийг л дамжуулдаг. Багш нар л тэр мэдээллийг агуулгыг нь бий болгодог улс. Одоогийн боловсролын тогтолцоонд өргөн хэрэглэгдэж байгаа сурах бичгийн арга барилаас болоод зарим багш нар энэ уургээ "мартахад" хүрсэн ч багш хүний хамгийн гол утга учир үүнд л оршоор ирсэн.

Цахим тоолуурууд багаж төхөөрөмжийн буруу ажиллагааг оношлох, тоон ажиллагааг үйлдэх зэрэгт гарамгай нь үнэн ч энгийн нохой муурны хийж чадах зүйлс тэдний хувьд боломжгүй. Хүмүүс биднийг онцгой болгож бусдаас ялгадаг чанар, оюун ухаан цахим тоолууруудад огт үгүй. Тэд шинэлэг зүйлсийг хэзээ ч бүтээж чадахгүй. Цахим тоолуурууд янз бүрийн хөгжим, урлагийг харуулж чадах боловч тэднийг үнэлж чадахгүй.

Цахим тоолууруудтай ажилладаг хүмүүс "хогоо оруулах, хогоо гаргах" гэдэг хэллэгийг өргөнөөр хэрэглэдэг. Энэ нь ихээхэн учиртай үг юм. Цахим тоолуурууд тэмдэгтүүдийн тогтолцоо, дүрсүүд, дуу авиаг утга санаанаас нь үл хамааран зүгээр л



дамжуулдаг. Тухайлбал, миний одоо хэрэглэж байгаа программ намайг юу бичиж байгаа талаар ямар ч юм мэдэхгүй зөвхөн миний дарсан товчны ардах дүрсийг л гаргаж өгч миний тушаасныг л хийж байгаа юм. Гэхдээ намайг хурдан бичих боломжоор энэ программ яалт ч үгүй хангаж байгаа нь маргаангүй. Гэвч программ миний ямар үгээр юуг илэрхийлж байгааг огтхон ч мэдэхгүй. Цахим програмууд бүгд адилхан. Багш сурагчид хоорондоо чухам ямар утгатай мэдээлэл солилцож байгааг тоолуур машин хэзээ ч мэдэхгүй. Ямар ч гэсэн цахим машинууд заах болон зурах чадварыг гайхамшигтайгаар өргөжүүлж байгаа нь үнэн билээ.

### СОЁЛЫН ХАМГИЙН САЙНЫГ НЬ ХУВААЛЦАХ НЬ.

Хувийн цахим тоолуурууд болон дүрс бичлэгийн төхөөрөмжүүдийг бид арваадхан жил л хэрэглэж байгаа нь технологи өсөн хөгжиж ирсэн хэдэн мянган жилтэй харицуулахад хэдхэн хоромтой тэнцэх богино хугацаа юм. Гэсэн хэдий ч технологи боловсролын үйл явцыг хэмжээлэшгүй хурднаар шинэчилж байна.

Өнөөгийн цахим технологийн тоног төхөөрөмж нь хэдхэн жилийн өмнөхөөс хамаагүй илүү хүч чадалтай болжээ. Бид өөрсдийн киног хийж, номоо хэвлэж болох болж. Удахгүй багш сурагчид цахим- дүрст програмыг ашиглан өөрсдийн сургалтын материалаа бэлдэж чаддаг болно. Үүнд цаг хугацаа, технологи, хэсэг хөрөнгө л шаардлагатай.

Гэвч технологи сайныг муугаас ялгаж, бидний соёл иргэншил мэдлэгийн хамгийн зөвийг нь сонгож үл чадна. Цахим тоолуур үзэл бодол үнэн хоёрыг ялгаж, үзэсгэлэн гоог үнэлж чадахгүй. Нэг үгээр хэлэхэд, шинэ техник технологи бидний дамжуулж буй мэдээллийн үнэ цэнийг мэдэхгүй. Багш бидний нэгэн чухал үүрэг бол энэ юм. Амьдрал, соёл иргэншлийн хамгийн сайныг нь багш бид л ялган салгаж хойч үедээ дамжуулан үлдээх ёстой юм. Үүнийг хэзээ ч мартаж учиргүй.

Алан Кэйн хэлснээр "Ирээдүйг таамаглах хамгийн сонгомол арга бол түүнийг бүтээх". Ирээдүй таны гарт байна. Гарт тань багаж нь ч байна.

### СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИЙН УДИРДЛАГЫН ЗАРИМ АСУУДАЛ

Н.Наранчимэг

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэл:

Боловсролын удирдлага  
Нийгмийн салбарын удирдлага  
Хүн ам, жэндер  
E-mail: ebnaran@yahoo.com

Стратеги нь сонгож авсан хэмжүүрүүд /үзүүлэлтүүд/ болон нөөц бололцоог үр дүнтэй ашиглахад тулгуурлан, тавьсан зорилгоо хэрэгжүүлэхэд нь зайлшгүй шаардлагатай удирдлагын үйл ажилгааны нэгдмэл загвар юм. Стратегийн удирдлага нь нөхцөл байдлыг бий болгох /асуудлыг гаргаж ирэх/, шаардлагатай өөрчлөлтүүдийг илрүүлэх /зорилгоо тодорхойлох/, шинэчлэлийн стратеги боловсруулах /тулгуур стратеги/, нөлөөллийн төрөл бүрийн аргыг хэрэглэх /стратегийг нэвтрүүлж хэрэгжүүлэх/, стратегийн зохицуулалт хийх /зохиох зохицуулалт хийх/ гэсэн 5 гол элементтэй.

*XXI зууны сургалтын байгууллагуудад стратеги боловсруулах шаардлага яагаад тулгарах болов?* Үүнийг дараах гол нөхцөлүүдээр тайлбарлаж болно:

- "Дахин үйлдвэрлэл"-боловсролын үйлчилгээний зах зээл нэмэгдсээр байна.
- "Шаардлагатай чанар"-орлого нэмэгдэн суралцагчдад сургалтын байгууллагыг сонгон суралцах боломж бий болсны үр дүнд иргэдээс боловсролын талаарх үйлчилгээнд тавих шаардлага дээшилж байна.
- "Шинэтгэл"-боловсролын үйлчилгээний эрс сайжруулсан техникийн, арга зүйн, зохион байгуулалтын боломж эрчимтэй нэмэгдэж байна /компьютер, бичил техник хэрэгслүүд, интернет ба зайны сургалт г.м/.
- "Хөдөлгөөнт чанар"-шинэ шинэ зүйлс амьдралд богино хугацаанд нэвтрэх болсонтой холбоотой боловсролын үйлчилгээний шинэ хувилбарыг мөн богино хугацаанд нэвтрүүлж байх шаардлага бий болжээ.
- "Өргөн хүрээ"-хүний үйл ажилгааны хүрээ өргөжиж байгааг дагалдан боловсролын үйлчилгээний төрөл болон тодорхой